

12

**МОНГОЛ УЛСЫН ХОТ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖЛИЙН ЯЛГАА:
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ШИЛЖИЛТИЙН НӨЛӨӨ**

С.Галбадрах

Манай орны хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа улам нэмэгдсээр байна. Хот, хөдөөгийн нэг хүнд ногдох орлого, хөдөлмөрийн бүтээмж үлэмж ялгаатай болжээ. Сүүлийн жилүүдэд хөдөөнөөс хот руу чиглэсэн хүн амын шилжилт ба аж ахуйн төвлөрөл эрчимтэй явагдаж байгаа нь судалгаанаас харагдаж байна. Хүн ам, аж ахуйн төвлөрлийн өнөөгийн үйл явцын сөрөг үр дагавар хот, хөдөөгийн аль алинд нь давамгайлж байх болно гэж бид үзэж байна.

Abstract. The disparity of rural and urban are increasing rapidly in our country with according to labour productivity and GDP per capita. Past years we can see from the survey that the increasing of rural-urban migration, also population and capital centralization are being acted intensively. Today's process of population and capital centralization e.g. a negative effect are dominating in both parts of rural and urban. We state that the basic trend of solving this problem will be a regionalization.

Түлхүүр үгс: дивергенци, хот, хөдөөгийн ялгаа, хүн амын шилжилт, регионализм

Key words: divergence, rural-urban disparity, migration, regionalization.

Ядуу буурай орон баян чинээлэг орнуудын нэг хүнд ногдох орлогын түвшинд ойртох чадах уу? (конвергенци явагдах уу?) гэсэн асуудал хөгжлийн эдийн засгийн хүрээнд тавигддаг. Шинэ сонгодог онолоор конвергенци явагдах боломжтой гэж үздэг. Үүнийг Солоугийн өсөлтийн загвар харуулдаг. Уг загвар нь урт хугацааны өсөлтийн загвар бөгөөд үйлдвэрлэлийн ба хүн амын хэрэглээний өсөлтөнд хуримтлал, хүн амын өсөлт, технологийн дэвшил хэрхэн нөлөөлдгийг харуулсан загвар юм.

Буурай хөгжилтэй улс орнууд богино хугацаанд түргэн хурдацтай хөгжсөний жишээ нь Азийн барууд гэж нэрлэгдэх орнууд юм. 1966-1990 онуудад Хонконг, Сингапур, Өмнөд Солонгос, Тайвань зэрэг улсуудын 1 хүнд ногдох орлого ойролцоогоор 7%-иар өсч байв. Харин АНУ зэрэг өндөр хөгжилтэй орнуудад мөн хугацаанд 2%-ийн өсөлттэй байсан. Эдгээр улсууд богино хугацаанд түргэн хөгжсөний шалтгааныг судлан үзээд inputs буюу үйлдвэрлэлийн орцууд (ажиллах хүч, капитал, менежмент г.м) байнга нэмэгдэж байсан нь түргэн өсөлтийн гол хүчин зүйл болжээ гэдгийг тогтоосон байна. Энэ нь хөдөлмөр эрхлэлт, капиталын хуримтлал өсч, боловсролын түвшин эрс сайжирсантай холбоотой байв./12/

Конвергенцийн эсрэг үйл явц нь дивергенци юм. Өндөр хөгжилтэй улс орнуудын өсөлт буурай хөгжилтэй улс орнуудынхаас илүү өндөр байж нэг хүнд ногдох орлогын зааг ялгаа улам бүр ихсэх үйл явцыг дивергенци гэдэг.

Улс орнуудын хооронд авч үздэгийн нэгэн адил улс орны дотоодод буюу бүс нутгуудын хооронд хөгжлийн зааг ялгаа болоход нөлөөлж байгаа хүчин зүйлсийг судлах явдал манай улсын хувьд чухал ач холбогдолтой. 2003 оны Хүний хөгжлийн илтгэлд хот, хөдөөгийн зааг ялгаа ихэсч байгааг тэмдэглэжээ. Хүний хөгжлийн индекс Улаанбаатар хот (0,735), Орхон (0,705), Дархан-Уул (0,677) аймагт бусад аймгуудаас өндөр байна.

Улс орны дотоодод капиталын ба хүн амын шилжилт чөлөөтэй явагддагаараа онцлог юм. Тэгвэл улс орнуудын хооронд эдгээр хүчин зүйлс чөлөөтэй шилжих чаддаггүй. Үүнд улс төр, эдийн засгийн зэрэг шалтгааны улмаас тогтоосон хязгаарлалтууд саад болдог.

Капиталын шилжих хөдөлгөөний конвергенцид үзүүлэх нөлөөг авч үзье. Капитал, хөдөлмөрийн харьцаа өндөр бүс нутгийн (хөгжлийн түвшин өндөр бүс нутаг) капиталын ахиуц бүтээгдэхүүн (MPK_1) уг харьцаа бага (хөгжлийн түвшин дорой) бүс нутгийнхаас (MPK_2) доогуур учир ($MPK_1 < MPK_2$) өндөр хөгжилтэй бүс нутгаас буурай хөгжилтэй бүс нутаг руу капитал шилжинэ. Солоугийн загвар дахь конвергенцийн механизм ийм маягаар явагддаг. Тэгвэл хөдөлмөрийн шилжих хөдөлгөөн уг үйл явцад хэрхэн нөлөөлөхийг авч үзье. Хөдөлмөрийн шилжилтийн үндсэн шалтгаан нь бүс нутгуудын цалингийн түвшний ялгаанаас үүдэлтэй. Тэгвэл хөдөлмөрийн шилжилт нь буурай хөгжилтэй бүс нутгаас өндөр хөгжилтэй бүс нутаг руу чиглэсэн байдлаар явагдана. Хөдөлмөр ба капиталын эсрэг

тэсрэг урсгалын үр дүнд бүс нутгуудын хөгжлийн зааг ялгаа багасах юм. Энэхүү төсөөллийг өөрийн орны нөхцөл байдалд ойртуулах үүднээс хөгжих буй орны хот-хөдөө загвараар төлөөлүүлэн авч үзье. Үүнд хөдөөд аж ахуй эрхлэх үндсэн хэлбэр нь уламжлалт хөдөө аж ахуйн салбар, хотод капитал эрчимтэй оролцсон аж үйлдвэрлэлийн салбар байх ба капитал, хөдөлмөрийн харьцаа ихээхэн зөрүүтэй байдаг гэе.

Толилуулж буй өгүүлэлд нийслэл хот ба Дархан, Орхон аймгуудыг хот гэсэн ангиллаар авч үзэв.(1999 оноос Дархан, Эрдэнэт хотуудыг аймаг болгосон) эдгээр нь хүн амын тоо болоод улс орны эдийн засагт гүйцэтгэж буй үүргээрээ томоохон хот гэсэн ангилалд хамаарна. Хэдийгээр статистикийн хотжилтын талаарх судалгаанд аймгийн төвийг хотын ангилалд оруулдаг ч эдгээрт аж үйлдвэр, үйлчилгээний салбар хөгжөөгүй, засаг захиргааны нэгжийн төдий үүрэг гүйцэтгэж байгаа юм. Сүүлийн жилүүдэд аймгийн төвүүдийн хувьд хотжих үйл явц явагдсангүй. 1995 оноос 2003 оны хүртэл 8 жилийн хугацаанд аймгийн төвүүдийн нийт хүнам жилд дунджаар 1.3 хувиар өсчээ. Энэ бол хүн амын төрөлт ба нас баралтыг тооцсон цэвэр өсөлтийн хувь бөгөөд хүн амын өсөлтөнд шилжилт хөдөлгөөн нөлөөгүй болохыг харуулж байна. Тэгвэл энэ хугацаанд Улаанбаатарын хүн ам жил тутам 4.6%-иар өсч иржээ.

Солоугийн загвараас урган гардаг капитал, хөдөлмөрийн харьцаа өндөр бүс нутгаас капитал, хөдөлмөрийн харьцаа доогуур бүс нутаг руу капиталын шилжилт явагдана гэсэн төсөөлөл бидний авч үзэж буй хот-хөдөө загварт тохирохгүй. Энэ нь хот, хөдөөгийн дэд бүтцийн ба ажиллах хүчиний мэргэжил, ур чадварын ялгаа зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой. Бүс нутгийн хөгжлийн тэнвэртгүй байдал хүрцдах онолд буурай хөгжилтэй бүс нутгийн хоцрогдлын шалтгааныг ийм байдалд хүргэж буй хөдөөгийн нөхцөлтэй нь холбож үздэг. Өөрөөр хэлбэл, эдгээр бүс нутагт ажил хэргийн идэвхжлийн хүчин зүйлүүд хангалтгүй байгаатай холбоотой хэмээн тайлбарладаг. Мөн үүнийг технологи нутагших үйл явцтай холбон үзвэл хөдөөд бүс хотод л нутагшина. Технологийн нутагшилт явагдах үндсэн суурь нь агломераци, түүний орчин байдаг билээ. Жеймс Симми (1998) бүс нутгийн инноваци, өндөр технологи бүхий аж үйлдвэрийн салбаруудын бөөгнөрлийн судалгаагаараа эдийн засгийн идэвхитэй үйл ажиллагаа газар нутгийн багахан орон зайд (агломерациудад) төвлөрч явагддагын шалтгааныг тайлбарласан. Бүс нутгуудад технологийн дэвшил харилцан адилгүй явагдах нь дивергенцид хүргэх хүчин зүйл болдог. Аймгуудын статистикийн мэдээ хангалтгүй байдгаас капиталын шилжилт хөдөлгөөнийг тодорхойлох боломж

байсангүй. Харин үүнтэй холбоотой анхаарал татаж буй нэг үзүүлэлт нь үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн тоо байлаа. Уг үзүүлэлтийг 1999-2003 онуудын хооронд Улаанбаатар, Дархан, Орхон, бусад цаймгууд гэсэн Зангиллаар саяч үзэхэд 1999 оны байдлаар улсын хэмжээнд нийт 18328 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байсны 42,7% нь Улаанбаатарт, 51% нь Дархан, Орхон, Улаанбаатарт үйл ажиллагаа явуулж байсан бол 2003 оны байдлаар 26552 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байсны 61% нь Улаанбаатарт, 67% нь Дархан, Орхон, Улаанбаатарт байлаа. Энэ хугацаанд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн тоо улсын хэмжээнд 8224, Улаанбаатарт 8470-аар тус тус өсчээ. Эндээс үзэхэд сүүлийн 4 жилийн өсөлтийнслэлд л бий болжээ. Аж ахуйн нэгжид ажиллагсдын тоо, үйл ажиллагааны цар хүрээг авч үзээгүй боловч (өнөөгийн төвлөрлийг харгалzan үзвэл эдгээр үзүүлэлтуудийн чиг хандлага ч дээрхийн нэгэн адил тодорхойлогдоно) үүгээр манай улсын бизнесийн орчны өнөөгийн дүртөрхийг тодорхойлж болох юм. Энэхүү асуудлыг нээлттэй эдийн засагт буюу гадаадын капиталын бурсгалтай холбон давчо үзье. М.Гуптас (1994) хөдөөнөөс хотруу чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөний нөхцөлд гадаадын капитал хотын ажил эрхлэлтийг нэмэгдүүлж, хөдөөгийн ажил эрхлэлтийг бууруулна гэж үзсэн. Тэрээр шинжилгээндээ $K_0 + k_R(1+v)$ байх нөхцлийг авч үзжээ. Үүнд: K_0 -хотын капитал, хөдөлмөрийн харьцаа, K_R -хөдөөгийн капитал, хөдөлмөрийн харьцаа, V -хүн амын шилжилт

2002 оны байдлаар манай улс дахь гадаадын хөрөнгө оруулалтын 94% нь Улаанбаатарт бүртгэлтэй байлаа [1]. Орон нутагт уул уурхайн төлбөрлөх салбарын гадаадын хөрөнгө оруулалт зонхиц байна. Уг салбарын гадаадын компаниуд тарчин үеийн техник, технологи ашиглаж байгаа тул ажилчдаагол төлөв хотоос авч ажиллуулж байна. Нарийн мэргэжлийн, өндөр үр чадвартай ажиллагсдын хувьд хөдөөд ажлын байр хомс тул үндсэндээ хотод төвлөрч (хөдөөнөөс хот руу шилжиж) байгааг тэмдэглэх хэрэгтэй. Энэ үүднээс уул уурхайн салбар дахь гадаадын хөрөнгө оруулалт хөдөөд ажил эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чухал нөлөөтэй гэж үзэх нь өрөөсгөл юм. Үүнээс үзэхэд М.Гупагийн авч үзсэн нөхцөл манай эдийн засагт тохирч байна. 1999-2003 онууд дахь хот ба хөдөөгийн ажиллагсад, ДНБ, хөдөлмөрийн бүтээмж, орлогын ялгааг хүснэгт 1-д харуулав.

Хүснэгт 1. 1999-2003 онууд дахь нийслэл хот, аймгуудын нэг ажиллагчийн хөдөлмөрийн бүтээмж, нэг хүнд ногдох орлогыг тооцсон нь

Ажиллагсад					
Хот, аймаг	1999	2000	2001	2002	2003
Улаанбаатар	209838	215503	221914	254222	290207
УБ, Дархан, Орхон	263725	263061	273871	306175	350732
Аймгууд	549834	545929	558440	564606	575806
Нийт	813559	808990	832311	870781	926538
ДНБ (1995 оны зэрэгцүүлэх үнээр мян.төг)					
Улаанбаатар	291295	315120	345250	361510	390980
УБ, Дархан, Орхон	341933	388079	390244	431147	472916
Аймгууд	283977	250934	248769	233721	229505
Нийт	625910	639013	639013	664868	702421
1 ажиллагчийн хөдөлмөрийн бүтээмж (мян.төг)					
Улаанбаатар	1388,2	1462,3	1555,7	1422	1347,2
УБ, Дархан, Орхон	1296,6	1475,2	1424,9	1408,2	1348,4
Аймгууд	516,5	459,6	445,4	413,9	398,5
Нийт	769,3	789,9	767,7	763,5	758,1
1 хүнд ногдох ДНБ (мян.төг)					
Улаанбаатар	383,2	400,7	424,9	427,1	437,6
УБ, Дархан, Орхон	373,7	409,7	400,3	426,2	448,3
Аймгууд	194,7	171,8	169,5	159,7	158,4
Нийт	263,7	265,4	261,6	268,6	280,5

Эх сурвалж: УСГ "Монгол улсын статистикийн эмхтгэл" УБ 2002, 2003 "2003 оны Монгол улсын ДНБ" судалгааны материал

Хот, хөдөөд нэг ажиллагчийн бий болгож буй нэмэгдэл өртөг буюу хөдөлмөрийн бүтээмж ихээхэн ялгаатай болжээ. 1999 онд хот, хөдөөгийн хөдөлмөрийн бүтээмжийн харьцаа 2.5:1 байсан бол 2003 оны байдлаар энэ үзүүлэлт 3.4:1 болжээ. (1999 оноос эхлэн статистикт аймгуудын ДНБ-ийг тооцож эхэлсэн тул 1999 оныг суурь он болгов) 2000-2002 онууд дахь ХАА-н үйлдвэрлэлийн уналт үүнд голлон нөлөөлжээ. Цалингийн түвшин хөдөлмөрийн бүтээмжээр тодорхойлогдоно. Хөдөөнөөс хот руу чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөнд хот, хөдөөгийн цалингийн ялгаа нөлөөлж байгаа ч хөдөөд малгүй болсон хүмүүс, аймаг, сумын төвийн ажилгүй хүмүүсийн хувьд ажил олдох илүү найдвартайг бодолцон зах зээлийн төвлөрөл даган хот руу шилжин ирж байна. Мөн хот, хөдөөгийн нийгмийн үйлчилгээний ялгаатай байдал шилжилт хөдөлгөөнд нөлөөлж байна. 1999-2003 онуудын хоорондох хот, хөдөөгийн хүн амын шилжих хөдөлгөөнийг авч үзье. 2000 онд явагдсан хүн ам, орон сууцны тооллогын үр дүнгээс үзэхэд 2000 оноос өмнөх 5 жилийн хугацаанд хүн амын цэвэр шилжилтийн (шилжин ирэгсдээс хасах нь шилжин явагсад) дунд 75357 хүнээр Улаанбаатарын хүн ам нэмэгджээ. Тэгвэл 2000-2003 онуудад хүн амын цэвэр өсөлтийг тооцохгүйгээр механик өсөлтийн үр дүн 103481 хүнээр

Улаанбаатарын хүн ам нэмэгджээ (хүснэгт 2). Энэ нь манай улсын хүн ам олонтой аймгуудын нэг болох Сэлэнгэ аймгийн хүн амтай дүйцэх тоо юм. Энэ нь хөдөөнөөс хот руу чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөн улам бүр эрчимжиж байгааг харуулж байна. Хүснэгт 2-оос үзэхэд хөдөөнөөс хот руу чиглэсэн хүн амын шилжилтийг Улаанбаатар дангаараа шингээж байна. Эдгээр нь албан ёсны бүртгэлтэй шилжин ирэгсдийн тоо юм. Үүний цаана хичнээн бүртгэлгүй хүн байгааг нарийн гаргасан тоо байхгүй байна.

Хүснэгт 2. 2000-2003 онууд дахь хүн амын механик өсөлт

Нийслэл хот, аймгууд	2000	2001	2002	2003
Улаанбаатар	19558	18730	26344	38851
УБ, Дархан, Орхон	24088	18787	27408	33749
Аймгууд	-23537	-17473	-25573	-34866

Эх сурвалж: УСГ "Монгол улсын статистикийн эмхтгэл" УБ 2002, 2003

Хүн амын өсөлтийн өндөр хурдац нь нэг хүнд ногдох капиталын хэмжээг бууруулж улмаар нэг хүнд ногдох орлогын түвшинг багасдаг хэмээн Солоугийн загварт авч үздэг. Хөдөөнөөс хот руу шилжин ирэгсдийн хувьд ажлын байраар тэр бүр хангагдаж чаддаггүйгээс шалтгаалан хотын ядуучуудын өгнээнд шилждэг. Ер нь шилжин ирэгсэд хотын нийгэм, эдийн засгийн амьдралын хүрээнд олон хүндрэлтэй асуудлыг бий болгож байгаа билээ. Хүмүүс суурьшсан газартаа өөрсдийн амьжиргааны эх үүсвэрээ хадгалах, түүнийг бий болгохыг эрмэлздэг. Энэ нь оршин тогтонохын төлөөх өрсөлдөөн юм. Хөгжиж буй олон улс орнуудад хөдөөнөөс хотруу чиглэсэн их нүүдлийн дүнд хүмүүс хотод суурьшин албан ёсны бус хэмээх асар их капиталыг бий болгон, хуримтлуулсныг Эрнандо дэ Сото (2000) тогтоожээ. Түүний судалгаагаар Гайти улсад албан ёсны бус үл хөдлөх хөрөнгийн дүн хууль ёсоор бизнес эрхэлж буй бүх компанийн нийт активаас 4 дахин, Перуд ийм үл хөдлөх хөрөнгийн бирж дээрх нийт үнэт цаасны үнэлгээнээс 5 дахин, Египетэд бүх хувьцааны үнэлгээнээс 30 дахин их байлаа. Гуравдагч ертөнцийн орнууд болон хуучин социолист системийн улс орнуудад хотын газрын 85%, хөдөөгийн газрын 40%-53% нь капитал үйлдвэрлэх боломжгүй эрх зүйн нөхцөлд байна. [11]. Манай улсын хувьд үүнийг албан бус сектортой холбож ойлгох нь илүү тохиромжтой. Шилжин ирэгсдийн хувьд үндсэндээ хөдөлмөр эрхлэх талбар нь албан бус сектор болдог. 2002-2003 онд явуулсан судалгаагаар ХАА-н бус салбар дахь албан бус секторт ажил эрхэлдэг нийт 126000 хүн байгаагийн 70,9% нь хотынх байлаа (уг судалгааны хот гэдэгт аймгийн төвүүд, Улаанбаатар хот багтсан) [9]. АНУ-ын олон улсын хөгжлийн агентлагаас 1999 онд явуулсан судалгаанаас үзэхэд хотын албан бус сектор ДНБ-ий 13,0% тай тэнцэхүйц байгааг тогтоожээ [5]. Эдгээр

судалгаа нь хүн амын шилжилт хөдөлгөөний эдийн засагт үзүүлэх үр дагаврыг арай зэрэг байр сууринеас харуулж байна. Дүгнэж үзэхэд хүн ам, аж ахуйн төвлөрлийн үр дүнд хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Үүний сөрөг үр дагавар хот, хөдөөгийн аль алинд нь давамгайлж байгаа юм. Бидний үзэж байгаагаар энэхүү асуудлыг шийдвэрлэх үндсэн хандлага нь регионализмын хандлага байх болно. Шилжилтийн эдийн засаг бүхий улс орнууд, буурай хөгжилтэй улс орнуудад бус нутгийн хөгжлийн хоцрогдлыг даван туулахад регионализмын гол үүрэг оршино. Регионализмыг бүсчилсэн хөгжлийн хандлагаар төлөөлүүлж ойлгож болохгүй. Регионализм нь эдийн засгийн бүсчилэлийг багтаасан бус нутгийн хөгжлийн тогтолцооны цогц үзэл баримтлал юм. Монгол улсын бүсчилсэн хөгжлийн хүрээнд хот, хөдөөгийн ялгаа, аймаг бус нутаг хоорондын тэгш бус байдлыг багасгах зорилго дэвшүүлсэн. Гэхдээ үүнд ямар арга замаар хүрэх вэ? гэдэгт асуудлын мөн чанар оршино. Энэ зорилгын үүднээс олон улсын, бус хоорондын аймаг хоорондын хөдөлмерийн хуваарыт тухайн бус нутгийн эзлэх байр суурийг оновчтой тодорхойлж, бус нутагт чиглэсэн бодлогыг явуулах шаардлагтай байна. Үүнтэй уялдан бус нутгийн эдийн засагт төрөлжилт явуулах, хөгжлийн үйл явцад уламжлалт бус хүчин зүйлсийг ашиглах асуудал чухлаар тавигдаж байна.

Ашигласан материал

1. Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг "Монгол дахь гадаадын хөрөнгө оруулалт 1990-2002" тайлан
2. С.Галбадрах "Эдийн засгийн ухаан" Дархан хот, 2001
3. Г.Гутман, А.Мироедов, С.Федин "Управление региональной экономикой" М., 2001
4. Грэгори Н.Мэнкью "Макро эдийн засаг" УБ., 2000
5. "Монголын хүний хөгжлийн илтгэл" УБ 2003
6. Б.Отгонтөгс, Б.Алтанцэцэг "Макро эдийн засаг" УБ 2000
7. ШУА-н үндэсний хөгжлийн хүрээлэн "Монгол улсын хөгжлийн судалгаа" УБ 2002
8. Үндэсний статистикийн газар "Хүн ам, орон сууцны тооллого 2000 он. Үндсэн үр дун" УБ 2001
9. Үндэсний статистикийн газар, Азийн хөгжлийн банк "Ажиллах хүчиний судалгааны үндсэн тайлан 2002-2003" УБ 2004
10. Үндэсний статистикийн газар "Монгол улсын статистикийн эмхтгэл" УБ 1997-2003
11. Эрнандо дэ Сото "Капиталын нууц" УБ 2004, 28-29-р тал
12. Alwyn Young "The tyranny of numbers" Journal of economics. Aug 1995
13. Gupta, Manash "Foreign capital, income inequality and welfare in a harris-Todaro model" Journal of development economics. 1994
14. Simmie, James "Innovate or stagnate: Economic planning choices for local production nodes in the global economy" Planning practice and research. Feb 98